



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/755

Булган сум

**"Бүгд Найрамдах Улс тунхагласны
баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Бүгд Найрамдах Улс тунхагласны өдөр" 11 дүгээр сарын 26-ны өдрийг угтан өмнөх ажлын өдрийг төрийн албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид үндэсний дээл хувцсаараа гоёж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Бүгд Найрамдах Улс тунхагласны баяр"-ын хичээл зааж хэвшүүлсүгэй.

2."Бүгд Найрамдах Улс тунхагласны өдөр"-ийг угтан өмнөх ажлын өдөр нь төрийн байгууллагууд тэмдэглэн өнгөрүүлж, иргэдээ соён гэгээрүүлсэн нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулж байхыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст даалгасугай.

3."Бүгд Найрамдах Улс тунхагласны өдөр"-ийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, Ерөнхий боловсролын сургуулиудад зааж хэвшихийг Боловсролын газарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

